



Үндэсний Татварын
Ерөнхий Газар

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР



ШИНЭ ХУУЛИАР
ТАТВАР БУУРЛАА



2007 ОН

ӨМНӨХ ҮГ

Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан татварын багц хуулиудыг 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэллээ. Эдгээр хуулиудаас Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг та бүхэнд толилуулж байна. Шинэ хууль агуулга, хэлбэрийн хувьд өмнө нь мөрдөж байсан хуулиас эрс шинэчлэгдсэнийг тэмдэглэж байна.

Шинэ хуулиар хувь хүний татварын ачааллыг бууруулах, ажиллах хүчний зардлыг багасгаснаар ажлын байр шинээр бий болгох, хуулийг энгийн хялбар болгож нэг мөр ойлгох, олон улсын жишигт нийцүүлэх алхмуудыг авч хэрэгжүүллээ.

Хуулийг иргэдэд ойлгомжтой тайлбарлах үүднээс шинэ хуулийн заалтуудыг өмнө нь мөрдөж байсан хуулийн заалтуудтай харьцуулсан хүснэгтийг товхимолд тусгалаа. Та хуулийг бүрэн эхээр нь Үндэсний татварын албаны www.mta.mn вэб хуудаснаас уншиж болно. Мөн хувь хүний орлогын албан татвар тодорхойлох тайлангийн шинэчилсэн маягтууд, тэдгээрийг нөхөх заавар, хөдөлмөр эрхлэлтийн сарын орлогыг тодорхойлох "тооны машин" зэрэг танд хэрэгтэй мэдээллийг товхимолд тусгалаа.

Та уг товхимлын цахим хувилбарыг манай вэб хуудас (www.mta.mn) - аас авч ашиглах боломжтой бөгөөд цаашид гаргах мэдээллийг илүү үр өгөөжтэй болгох үүднээс Таны саналыг бид өөрийн вэб хаягаар хүлээн авахад таатай байх болно.

ДАРГА



Л. ЗОРИГ

ГАРЧИГ

ХУУЛИЙН ЗААЛТУУД	1-8
Албан татвар төлөгч.....	2
Оршин суугч статус	2
Албан татвар ногдох орлого.....	2
Харилцан хамаарал бүхий этгээд.....	4
Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох.....	4
Малчин өрхийн орлого.....	4
Чөлөөлөгдөх орлого.....	6
Албан татварын хувь, хэмжээ.....	8
Албан татварын хөнгөлөлт.....	8
ТАТВАРЫН ТООНЫ МАШИН	9-10
ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР ТОДОРХОЙЛОХ ТАЙЛАНГИЙН ХУУДАС	11-12
Тайлангийн хуудас нөхөх заавар.....	13-17
МАЛЧИН ӨРХ, МАЛ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ	18

ХУУЧИН ХУУЛЬ

Албан татвар төлөгч	<ul style="list-style-type: none"> ◆ Монгол Улсын иргэн, гадаадын иргэн ◆ харьяалалгүй хүн, Монгол Улсад орлого олсон оршин суугч бус этгээд
Оршин суугч статус	<ul style="list-style-type: none"> ◆ оршин суугч (12 сарын хугацаанд 183-аас дээш хоног, хэвийн ажиллах байртай, гадаадад томилогдон сууж байгаа Монгол Улсын иргэн): орлогын бүх эх үүсвэр ◆ оршин суугч бус: зөвхөн Монгол Улсад олсон орлого
Албан татвар ногдох орлого	<ul style="list-style-type: none"> ◆ үндсэн болон бусад ажлын газраас авсан цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого ◆ тэтгэвэр, тэтгэврийн нэмэгдэл, тэтгэмж ◆ аж ахуй эрхэлсний орлого ◆ хувиараа бараа, материал, түүхий эд бэлтгэж борлуулсны орлого ◆ хөрөнгийн хөдлөл, эрхийн орлого ◆ үл хөдлөх хөрөнгө борлуулсан орлого, адилтгах бусад орлого ◆ хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого ◆ хөрөнгө түрээслүүлсний орлого, адилтгах бусад орлого ◆ зохиогчийн эрх, патент, адилтгах бусад орлого ◆ зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлого, адилтгах бусад орлого ◆ шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл, адилтгах бусад орлого ◆ урлагийн тоглолт, спортын уралдаан, тэмцээний шагнал ◆ бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалааны хонжворын орлого ◆ албан татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад орлого

ШИНЭ ХУУЛЬ

Албан татвар төлөгч	<ul style="list-style-type: none"> ◆ Монгол Улсын иргэн, гадаадын иргэн ◆ харьяалалгүй хүн, Монгол Улсад орлого олсон оршин суугч бус этгээд
Оршин суугч статус	<ul style="list-style-type: none"> ◆ оршин суугч (12 сарын хугацаанд 183-аас дээш хоног, оршин суух байртай, гадаад улсад томилогдон ажиллаж байгаа Монгол Улсын төрийн албан хаагч): орлогын бүх эх үүсвэр ◆ оршин суугч бус: зөвхөн Монгол Улсад олсон орлого
Албан татвар ногдох орлого	<ul style="list-style-type: none"> ◆ цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого: <ul style="list-style-type: none"> ● амралтын олговор, ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж, бэлэг, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал ◆ үйл ажиллагааны орлогод: <ul style="list-style-type: none"> ● мэргэжлийн үйлчилгээ, үйлдвэрлэл, арилжааны орлого, тогтмол бус үйл ажиллагааны орлого ◆ хөрөнгийн орлогод: <ul style="list-style-type: none"> ● түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүү, патент, адилтгах бусад орлого ◆ хөрөнгө борлуулсны орлогод: <ul style="list-style-type: none"> ● үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого ◆ шууд бус орлого - ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй бараа, үйлчилгээний орлого: <ul style="list-style-type: none"> ● үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн ● орон сууцны ашиглалтын зардлын төлбөр, бэлнээр олгосон байрны хөлс, түлшний зардал ● бэлнээр олгосон хоолны мөнгө, түүнчлэн үзвэр үйлчилгээний олговор ● ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгчийн болон бусад үйлчилгээ үзүүлсний зардал ● өр барагдуулсны төлбөр ● арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү ● адилтгах бусад орлого

ХУУЧИН ХУУЛЬ

Харилцан хамаарал бүхий этгээд	<ul style="list-style-type: none"> ◆ заалт байгаагүй
Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> ◆ үндсэн ажлын хэлбэрээр олсон орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр ◆ үндсэн бус ажлын хэлбэрээр олсон орлогын нийлбэр дүнгээр ◆ Аж ахуйн үйл ажиллагааны орлогоос холбогдох зардлыг хассан дүнгээр ◆ тэтгэвэр, тэтгэврийн нэмэгдэл, тэтгэмжийн дүнгээр ◆ хөрөнгө хөдлөлийн орлогын нийт дүнгээр ◆ бусад орлогын нийт дүнгээр
Малчин өрхийн орлого	<ul style="list-style-type: none"> ◆ малчин өрх, мал бүхий этгээдийн албан татвар ногдуулах орлогыг малын тоогоор тодорхойлно ◆ аймаг, бүс нутгаар ялгаатай

ШИНЭ ХУУЛЬ

Харилцан хамаарал бүхий этгээд	<ul style="list-style-type: none"> ◆ харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдэх жишиг үнээр үнэлнэ ◆ харилцан хамаарал бүхий этгээдэд албан татвар төлөгчийн эцэг, эх, хүүхэд, өвөө, эмээ, ач, зээ, ах, эгч, дүү, эсхүл тэдний хүүхэд, эхнэр, нөхөр, эсхүл тэдний эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү
Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> ◆ цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр ◆ тэтгэмж, бэлэг, гадаад, дотоодын этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, бусад адилтгах орлогын нийт дүнгээр ◆ үйл ажиллагааны орлогоос холбогдох зардлыг хассан дүнгээр ◆ хөрөнгө түрээслүүлснээс олсон нийт орлогоос тухайн хөрөнгийг түрээслүүлэхтэй холбогдон гарсан зардлыг хассан зөрүүгээр ◆ эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлогын нийт дүнгээр ◆ үл хөдлөх эд хөрөнгө борлуулснаас олсон орлогын нийт дүнгээр ◆ хөдлөх эд хөрөнгө борлуулснаас олсон орлогоос тухайн хөрөнгийг худалдан авсан болон ийнхүү худалдан авахтай холбогдон гарсан баримтаар нотлогдох зардлыг хассан зөрүүгээр ◆ бусад орлогын нийт дүнгээр
Малчин өрхийн орлого	<ul style="list-style-type: none"> ◆ малчин өрх, мал бүхий этгээдийн албан татвар ногдуулах орлогыг малын тоогоор тодорхойлно ◆ аймаг, бүс нутгаар ялгаатай

ХУУЧИН ХУУЛЬ

Чөлөөлөгдөх орлого	<ul style="list-style-type: none">◆ хуульд заасны дагуу олгож байгаа тэтгэмж, нөхөн олговор◆ Монгол Улсын төрийн болон нэрэмжит шагнал◆ донорт олгосон орлого◆ томилолтын зардал◆ даатгалын нөхцөлөөр олгосон олговор◆ Засгийн газрын зээллэгийн нөхөн олговор болон хүүгийн орлого◆ хөдөлмөр хамгааллын хувцас◆ дипломат төлөөлөгчийн буюу консулын газар◆ амьдран суух зориулалтаар хувьдаа орон сууцны барилга барих, худалдан авахад зориулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлого◆ дотоодын их, дээд болон тусгай мэргэжлийн сургуульд суралцагч хүүхдийн сургалтын төлбөр◆ боловсролын сан, нийгэмд үйлчилдэг, улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандив◆ мал бүхий өрхийн гишүүн бүрт хонин толгойд шилжүүлснээр 20 бог
---------------------------	--

ШИНЭ ХУУЛЬ

Чөлөөлөгдөх орлого	<ul style="list-style-type: none">◆ хуульд тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэмж, нөхөн олговор, нэг удаагийн буцалтгүй тусламж◆ донорын олговор◆ албан томилолтын зардал◆ даатгалын нөхөн төлбөр◆ Засгийн газрын өрийн бичиг /бонд/-ийн төлбөр, хүү, анз◆ хөдөлмөр хамгааллын хувцас◆ гамшгийн үед бусдаас үзүүлсэн тусламж◆ дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн орлого◆ хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлого◆ Монгол Улсын төрийн болон нэрэмжит шагнал◆ анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого◆ мал бүхий өрхийн гишүүн бүрт хонин толгойд шилжүүлснээр 20 бог◆ ажил олгогчоос олгосон шууд бус орлого:<ul style="list-style-type: none">◆ ажлын цагаар ажиллуулдаг цайны газар, кафе, амралтын өрөөнд бүх ажилтныг хоолоор хангах◆ алслагдсан ажлын байранд ажилладаг ажиллагсдыг амрах байр, бусад үйлчилгээгээр хангах◆ ажлын байранд ирэх, буцахад нэгдсэн журмаар унаагаар үйлчилсэн◆ орон сууц худалдан авах, барихад зориулж ажилтанд арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү;◆ эмчилгээний зардал
---------------------------	--

ХУУЧИН ХУУЛЬ

Албан татварын хувь, хэмжээ	<ul style="list-style-type: none"> ◆ 2,400,000- 10%; 4,800,000-20%, түүнээс дээш 30% ◆ түр болон оршин суугч бус этгээдийн орлогод 20% ◆ дивиденд, хүүгийн орлогод 15% ◆ бооцоот болон тааварт тоглоом, хонжворт сугалаа, урлагийн тоглолт, биеийн тамир, спортын уралдаан, тэмцээний шагналын орлогод 10% ◆ гадаад улсад үзүүлсэн үйлчилгээнээс олсон орлого 10% ◆ бараа, материал, тvvхий эд худалдах 3% суутгал ◆ үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод 2% ◆ шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогчийн шагнал болон адилтгах бусад шагналын 5000000 хүртэлх төгрөгийн орлогод 5%, 5000001, түүнээс дээш төгрөгийн орлогод 10%
Албан татварын хөнгөлөлт	<ul style="list-style-type: none"> ◆ жилийн 48000 төгрөг ◆ үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлээс олсон орлогод ногдох албан татварыг 50%

ШИНЭ ХУУЛЬ

Албан татварын хувь, хэмжээ	<ul style="list-style-type: none"> ◆ цалин хөлс, үйл ажиллагаа, хөрөнгийн орлогод 10% нэг шатлал ◆ төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлогод 40% ◆ үл хөдлөх эд хөрөнгө борлуулснаас олсон орлогод 2% ◆ урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагналын орлогод 5% ◆ шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч, шинэ бүтээл, адилтгах бусад орлогод 5%
Албан татварын хөнгөлөлт	<ul style="list-style-type: none"> ◆ жилийн 84000 төгрөг ◆ давхар татварын гэрээтэй гадаад улсад төлсөн татвар ◆ үр тариа, төмс, хүнсний ногоо, сүү, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамлын үйлдвэрлэлээс олсон орлогод ногдох албан татварыг 50%



АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төслийн туслалцаатай бэлтгэн хэвлэв.